

ОЮУТАН ЗАЛУУЧУУДЫН ХҮМҮҮЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

И. И. Зарецкая

Хураангуй: Орос улс нь Болонь конвенцид нэгдэн орсноор дээд боловсролынхоо агуулгыг европын боловсролын орон зайд нийцүүлэх хэрэгтэй болов. Дээд боловсролын эрдэм шинжилгээний болон мэдээллийн бүрдэл хэсгүүдийг интеграцчилж болно. Боловсролын соёл судлалд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ бүс нутгийн боловсролын тогтолцооны соёл, угсаатны зүйн уламжлалыг харгалзан бие хүнийг хөгжүүлнэ.

Түлхүүр үг: дээд боловсрол, бие хүний хөгжил, интеграци, үнэт зүйлс, үндэс угсаа, уламжлал, Болонь процесс, баруун, зүүний иргэншил, нийгмийн идэвхжил.

Орчин үеийн нийгэм – эдийн засгийн нөхцөлд Оросын оюун ухаан, соёл, нийгэм, шинжлэх ухаан – техникийн нөөц чадамжийг төлөвшүүлэхэд дээд боловсролын гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдсээр байна. Боловсролыг нийгмийн эрхэм дээд үнэт зүйл, үндсэн капитал - хүнийг үйлдвэрлэх салбар хэмээн тунхаглаж байна. Тэгэхдээ мэргэжлийн боловсролын чанарт тавих шаардлага нь оюутныг тодорхой мэргэжлийн хүрээний мэргэжилтэн байдлаар төдийгүй өөрийгөө эх орныхоо болон дэлхийн иргэн хэмээн ойлгож ухамсарласан оюун санаа – ёс суртахуун бүхий соёлтой бие хүнийг бэлтгэхэд чиглэж байна. Мэргэжлийн боловсролын чанарын асуудлыг судлан шинжлэхэд хүн судлалын үүднээс хандахыг өнөөдөр түүний хөгжлийн чиг хандлага харуулж байна.

Орос улс Болонь конвенцид нэгдэн орох болсон нь дээд боловсролын олон үндэстний өөр өөр тогтолцоог харьцуулан авч үзэх, европын боловсролын нэгдсэн орон зайг бий болгохтой холбоотой. Ингэхдээ захиргааны шийдвэр гаргах хүрээнийхэн болон их, дээд сургуулиудын удирдагчдын анхаарал илүү

их төвлөрсөн зүйл бол дээд боловсролын шатлалтай тогтолцоог хэрэгжүүлж, бакалавр, магистрантурыг нэвтрүүлэх явдал байв.

Үүнтэй уялдан бакалаврын түвшинд мэргэжилтэн бэлтгэх талаарх ойлголт бүдэг бадаг; ажил олгогчдын зүгээс бакалаврын дипломд үл итгэсэн байдлаар хандаж байсан зэргээс шалтгаалан асуудал тулгарах болов. Жишээлбэл, Таллины эдийн засаг, менежментийн дээд сургууль, К.Г.Разумовскийн нэрэмжит Москвагийн технологи, удирдлагын улсын их сургууль зэрэг хэд хэдэн их, дээд сургуульд үйлдвэрлэлийн дунд шатны менежер, технологичдыг бэлтгэх зорилгоор бакалаврын хавсарга анги нээх хэрэгтэй гэсэн дүгнэлт хийж байв.

Уг нь Болонь конвенцийн үзэл санаа (одоо - дээд боловсролын европын орон зайн үзэл санаа – хэмээн нэрлэх болсон) илүү өргөн хүрээг хамарсан төгс агуулгатай билээ. Тухайлбал:

- дээд мэргэшлийн европын хөдөлмөрийн нэгдсэн зах зээл, боловсролын нэгдсэн орон зай бий болгох;
- Европын боловсролын хүртээмжийг өргөтгөж, оюутан, багш нарын мэргэжлийн чадамжийг хангах;
- Европын бүх улс оронд хүлээн зөвшөөрөгдөх дипломын хавсралт олгодог дээд боловсролын шатлалтай болох;
- үндсэн гол үнэт зүйлсийг тогтооход баримтлах европын чиг хандлагыг баталж, төлөвшүүлэх.

Интеграцчилах үйл явц нарийн түвэгтэй, түүнийг хэрэгжүүлэх боломжийн шинжилгээг хийхдээ нийгэм – соёлын орчны онцлогийг харгалзахгүй бол сайн үр дүнд хүрэхгүй гэдгийг тооцохгүй байж болохгүй. Хэрвээ дээд боловсролын уламжлалт - үйлдвэрлэл



болон мэргэжлийн мэдлэг, чадвар, чадамжийг дамжуулахад чиглэсэн эрдэм шинжилгээ – мэдээллийн чиг үүргийг гол болговоос энэ нь интеграцид амархан орно гэдэгтэй санал нийлж болно. Мэргэжлийн тусгай боловсролын агуулга онцгой байж болох бөгөөд энэ хүрээнд харин мэргэжилтэн бэлтгэх интеграцчилсан нэгдсэн стандарт байж болох юм. Гэхдээ орчин үеийн мэргэжлийн боловсролын чиг үүрэг эрдэм шинжилгээ –мэдээлэл, мэргэшлийн асуудлаар хязгаарлагдахгүй. Дээд боловсролын зорилго бол дан ганц тодорхой түвшний мэргэжилтэн бэлтгэх асуудал хараахан бус. Мэргэжлийн дээд, дунд боловсролын стандартад мэргэжилтэн бэлтгэх шаардлагуудыг шинээр тодорхойлохдоо мэргэжлийн боловсролын нийгэмшүүлэх, үнэт зүйлсийн баримжаатай болгох, соёл судлалын чиг үүргийн ач холбогдлыг анхаарч үзсэн нь тохиолдлын хэрэг биш.

Эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн боловсролд хүн судлал, хөгжлийн дээд түвшний сэтгэл судлал, үнэт зүйлсийн онолын орчин үеийн чиг хандлагын үүднээс хандах хэрэгтэй болно. Дээр дурдсан чиг үүргүүд нийгмийн “генетикийн код”, түүний уламжлал, угсаатны үнэт зүйлс, соёлын баялгийг хадгалж, дамжуулахтай холбоотой. Соёл – үнэт зүйлсийн чиг баримжааны цогц байдлаар бие хүний хөгжилд чиглэсэн эдгээр чиг үүргийг багцлан төсөөлж болно. Олон үндэстэн, олон ястан угсаатан, олон соёл бүхий Орос орны төлөв байдал, евроазийн нийгэмлэгийн төв болохуйц газарзүйн өвөрмөц онцлог, дэлхийн янз бүрийн шашин, ард түмний хэлний төрөл бүрийн бүлгийн болон уламжлалын холилдон сүлэлдэх хүрээ – энэ бүхэн нийгэм-соёлын хөгжилд мэдэгдэхүйц ул мөр үлдээж байна. Ард түмнүүдийн үндэсний соёлын өвөрмөц байдлыг хэвээр хадгалах, тэдгээрийн иргэншлийн онцлог, уламжлалын үнэт зүйлсийн бүтцийг харгалзах хэрэгтэй. Харамсалтай нь, удаан хугацаанд үндэстний асуудал, соёлын онцлог, ард түмний зан заншлыг харгалзахгүйгээр хүмүүжил олгох үйл явцыг хэрэгжүүлсээр ирсэн байна. Хэд хэдэн бүс нутагт хүмүүжлийн талаар баримтлах ард түмний уламжлалт үндэс,

угсаатны сурган хүмүүжүүлэх зарчим зэргийг үгүйсгэж байсны харгайгаар төрөлх хэл, соёл, түүхээ мэдэхгүй өсвөр залуу үе төлөвшиж бий болжээ. Соёлын болон түүхийн хөгжлийн харьцааны асуудлыг өөрөөр хүлээж байгаа нь нөхцөл байдлыг улам түвэгтэй болгож байна. Өнгөрсөн үед нийгмийн цикл соёлынхоос хавьгүй богинохон байв. Хорвоод мэндэлсэн хүн соёлын үнэт зүйлсийн тодорхой бүтцийг өвлөн авч тэр нь зуун зууны туршид өөрчлөгдөлгүй хадгалагдан туршлага, уламжлалыг үеэс үед дамжуулах асуудал зохицуулагдсаар ирсэн. XX зуунд нийгмийн болон соёлын циклийн хооронд тасархай орон зай бий болов: нэг үеийнхний амьдралын туршид одоо хүн соёлын эрин өөрчлөгдөхийг биеэр үзэж амсаж байгаа бөгөөд үүнийг бид ялангуяа гурав дахь мянганы босгон дээр илүү онцгой мэдэрч байна. Соёлын олон эшт үзлээр дамжин түгээмэлд тэмүүлж, соёлын өвийг хэвээр хадгалж, түгээн дэлгэрүүлж, арвижуулан баяжуулж чадсанаар дэлхийн олон соёлын өөдөөс угтан алхах хэрэгтэй тухай үүссэн асуудалд ЮНЕСКО – гийн баримт бичгүүд бидний анхаарлыг хандуулж байна.

Мэргэжлийн чадамжаас гол түлхүүр чадамжийн хөгжлийг дээгүүр авч үзэх нь гарцаагүй чухал бөгөөд энэ бол үнэхээр аливаа нөхцөл байдалд дасан зохицох, өрсөлдөх чадвартай байхын нөхцөл мөн. Эрэн сурвалжлах идэвхжил, шаргуу хичээл зүтгэл, сонголт хийх нөхцөлд бие дааж шийдвэр гаргахад бэлэн чанар, өөрийн үйл ажиллагааны үр дүн, үр дагаврын төлөө хариуцлага хүлээх зориг, багт ажиллах чадвар, зохион байгуулалтын, мэдээллийн, харилцааны соёл – энэ бүгд мэргэжлийн үйл ажиллагааны тодорхой агуулгаас үл хамаарах мэргэжилтний чадамжийн үзүүлэлт бөгөөд үүгээр өөрийгөө Европын ямар ч улс оронд танилцуулах боломжтой. Мэргэжлийн сургууль төгсөгчдийн мэргэжлийн чадамж, өрсөлдөх чадвар ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ үндэсний, угсаатны соёлын уламжлалд тулгуурлан тэдний оюун санаа – ёс суртахууны хувьд хөгжүүлэх боломжийг алдаж болохгүй. Олон үндэстэн ястан бүхий Орос орны нөхцөлд

бие хүний хөгжлийн вектор, байр суурийг тодорхойлогч оюун санааны болон соёлын үнэт зүйлс нь мэргэжлийн боловсролын зорилгыг илүү өргөн болгож байна. Үүнийг эрдэмтэд, практикийн багш нарын хэн хэн нь ухаарч, ойлгож байна. Ардын соёлын баялагт тулгуурлан оюутан залуучуудыг хүмүүжүүлэх чиглэлийн судалгаа сүүлийн үед идэвхжих болсон нь тохиолдлын хэрэг бус. Тухайлбал, 2009 онд “Бүс нутгийн угсаатны хүмүүжлийн чиглэл бол сурган хүмүүжүүлэх үйл явцын тогтолцоо бүрдүүлэгч хүчин зүйл болох нь” сэдвээр Чуваш улсын материалаар М. Б. Кожанова докторын зэрэг хамгаалсан; М. И. Алдошина (Орловын улсын их сургууль) “Их сургуулийн боловсролын үйл явцад оюутнуудад угсаатны гоо зүйн соёл төлөвшүүлэх нь” сэдвээр судалгаа хийлээ. Казанид мөн ийм чиглэлийн судлагааг Г.В.Мухаметзянова хийсэн байна.

Энэ асуудалтай холбогдуулан үндэсний болон дэлхийн соёлын субъект болох талаас нь бие хүнийг хөгжүүлэх зорилготой мультимедиа боловсролын агуулга боловсруулахаар Татарын хүмүүнлэг – сурган хүмүүжүүлэх ухааны их сургууль (ялангуяа профессор З. Г. Нигматова) – ийн санаачилгыг тэмдэглэх хэрэгтэй. Жил бүр энэхүү их сургуульд хүмүүжлийн асуудлаар бага хурал болж байна. 2007 оны бага хурлыг “Олон соёл бүхий боловсролын орон зайн нөхцөл дэх үндэсний соёлын хүмүүжлийн нөөц боломж” сэдвээр зохион байгуулсан. Ийм нэгэн бага хурал дээр Татарын ардын яруу найрагч Гадулл Тукайд зориулж: “Тэр бол татарын ард түмний найрагчийн зэрэгцээ оросын яруу найргийн нэрт төлөөлөгч бөгөөд энэ нь өөрөө түүнийг дэлхийн соёлд хамааруулж байгаа” тухай дурдсан байдаг. Үндэсний хэмжээн дэх хүмүүжлийн асуудал шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж буй өнөө үед олон үндэстний буюу мультисоёлын боловсролын асуудал болон хувирч үүнээс улбаалан өөрийн үндэсний хийгээд дэлхийн соёлын субьектийн хэмжээнд бие хүнийг хөгжүүлэх таатай орчин нөхцөл бүрдүүлэх чиглэсэн зорилго бүхий үйл явц өрнөж байна. Чухамхүү энэ үйл явцын хүрээнд мультисоёлын боловсрол олгох үндсэн

зорилтуудыг тодорхойлж, зохион байгуулах багц зарчмыг боловсруулсан болно.

Тухайлбал:

- эх хэлний эзлэх байр, гүйцэтгэх үүргийг сургалтын хэл, эсвэл зөвхөн тухайн хичээлийг судлах хэл, эсвэл сонгон судлах хэл зэргээр тодорхойлох;
- ардын сурган хүмүүжүүлэх зүйн мэргэн ухаанд тулгуурлан оюутнуудыг оюун санааны хувьд хөгжүүлэх зорилгоор орон нутаг судлах, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах;
- соёлын солилцооны үндсэн дээр болон эрдэм шинжилгээ – судалгаа, өөрчлөн байгуулалт, соёлын бүтээлч үйл ажиллагааны хүрээнд янз бүрийн соёлын төлөөллийн харилцан үр бүтээлтэй ажиллах туршлагыг хөгжүүлэх үндэс болгож, бусад үндэстэн ястны соёлд оюутнуудыг интеграцчилан татаж оролцуулах;
- соёлын үнэт зүйлсийг зөвхөн хэрэглэгч төдийгүй тэдгээрийг тээгч, бүтээгч, дамжуулан түгээгчдийнх нь хувьд үндэсний соёлыг судлах, хадгалах, хөгжүүлэх зорилгоор оюутны нийгмийн ажлын дадлага зохион байгуулах;
- ирээдүйн мэргэжилтнүүдийн ухамсарт дорнын соёлын үнэт зүйл болсон: хөдөлмөрт дуртай байх, ахмадыг болон удам угсаа, бие хүн хоорондын харилцааны соёлыг дээдлэн хүндлэх үзлийг суулгах;
- хүлээцтэй хандах чанар (толерантность), олон талт соёлын үнэт зүйлсийг ухамсарлуулах корилгоор оюутан залуусыг өөрийнхөө ард түмний соёлын үнэт зүйлсийг эзэмшихээс бүс нутаг, бүгд найрамдах улс дахь бусад ард түмний ёс заншил, шашин шүтлэгийг ойлгож хүлээж авахад хөтлөн дагуулах;
- соёлын интеграцчилалд дэмжлэг болохуйц: тухайн ард түмний соёлын өдрүүд, үндэсний баяр наадам, ёслол, үндэсний чиглэлтэй урлаг, уран бүтээлийн хамтлагийн үйл ажиллагаанд анхаарал тавих гэх мэтээр танхимаас гадуурх үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг хөгжүүлэх. А. В. Кирьякова, З. Г. Нигматова нарын онолын судалгаанд: нээлттэй байх; янз бүрийн ард түмэн, соёлын төлөөлөл тэгш боломжтой байх; оюутны бие



хүний хөгжлийг тэргүүлэх түвшинд тооцох; олон хэлтэй болгож бэлтгэх; үндэсний соёлын уламжлалаас бүс нутгийн боловсролын орон зай бүрдүүлэхэд, өөрийн ард түмний төлөөлөл байх, улмаар европын боловсролын орон зайн субъект байх нэр төрийн мэдрэмж бий болгох замаар даян дэлхийн боловсролын орон зайд интеграцчилахад аажмаар шилжих зэрэг мультисоёлын боловсролын тэргүүлэх зарчмуудад анхаарал хандуулсан байна. Олон үндэстэн ястантай Орос орны тодорхой ард түмний оюун санааны болон соёлын үнэт зүйлсийг эзэмшсэн өрсөлдөх чадвартай мэргэжилтэнд европын үнэт зүйлсийг интеграцчилан төлөвшүүлж бэлтгэх нь улс орны боловсон хүчний нөөцийг шинжлэх ухааны суурь бэлтгэлтэй, чөлөөтэй, бүтээлчээр ажиллах чадвартай, өндөр мэргэжилтэй, оюун санаа хувьд баян мэргэжилтнээр баяжуулах мэргэжлийн дээд боловсролын нийгэм – түүхийн чухал зорилгыг биелүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Өөрийн ард түмний ёс суртахууны үнэт зүйлд үнэнч, соёлтой иргэн болж төлөвших оюутны бие хүний хөгжилд нийгмийн чиглэлийн дадлага ажлын хэлбэрийг хөгжүүлэх явдал тус дөхөм үзүүлнэ. Оюутнуудын оюун санаа – ёс суртахууны хөгжилд орон нутаг судлах, ард түмний түүхэн алдар гавьяа, соёлын уламжлалаас суралцах, охь манлайг нь тээх, хадгалах, дамжуулах уялдаа бүхий нийгэм-соёлын дадлага үр нөлөөтэй байдаг. Оюутны нийгмийн ажлын дадлагад хүн, байгаль, нийгэм зохилдон хамтдаа өв тэгш хөгжих зарчимд суурилсан экологийн шинэ чиг баримжааны сэтгэлгээ төлөвшүүлэх хэрэгцээ шаардлагатай холбоотой неосферын боловсролын үзэл санаа онцгой чухал болж байна. Нийгэмд үнэ цэнтэй, бүтээлч үйл ажиллагааны туршлага бий болгох, бие даах, хариуцлагатай байх чадварын хөгжилд тухайн үедээ оюутны отрядын хөдөлгөөн ихээхэн хувь нэмэр оруулдаг байсан. Энэхүү хөдөлгөөн өнөөдөр сэргэж, найдвартай ажил олгогч – үйлдвэрийн газруудын нийгэм, эдийн засгийн түншлэлийн боломжуудыг харгалзаж байгаа нь туйлын үнэ цэнтэй бөгөөд нийгмийн ажлын дадлагын мэргэжлийн чиглэл баримталж, ажлын байр, амьралын

явц дахь (контекстийн) сургалтын зарчмыг (А. А. Вербицкий) хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Оюутан залуучуудын дунд нийгмийн тусламж дэмжлэг шаардлагатай хүмүүст туслахад чиглэсэн сайн дурын хөдөлгөөн улам өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж байна. Ийм үйл ажиллагаа нь И. Д. Демаковагийн тодорхойлсноор “хүйтэн сэтгэлийн эсрэг тарилга” болж байна. Дээд сургуульд хүмүүжлийн ажил зохион байгуулагчдын анхаарал хандуулж байгаа өөр нэг асуудал бол профессор – багш нарыг хүмүүжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд татан оролцуулахад хүндрэлтэй байгаа явдал юм. Багш нарын зүгээс оюутнуудад үзүүлэх хүмүүжлийн нөлөөний гол нөөц нь эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа юм. Нэгд, ийм үйл ажиллагаа зохион байгуулахад бүх тэнхим оролцдог. Хоёрт, хатмын судалгаа, шинжилгээний явц бол эхлэн судлаачид эрдмийн эрэл хайгуулыг зохион байгуулах үндсийг төдийгүй судалгааны ажилд сэтгэлээсээ хандах, үнэт зүйлийн өөрсдийн тогтолцоог өвлүүлэн дамжуулах туршлагатай багш нартайгаа хамтарч харилцан ажиллах орон зай болдог.

Ийнхүү мэргэжлийн боловсролын чанарт тавих шинэ шаардлагууд нь ирээдүйн мэргэжилтнийг бие хүнийх нь хувьд хөгжүүлэхэд чиглэсэн хүмүүжлийн цогц зорилтуудаас: өрнө, дорны иргэншлийн үнэт зүйлсийг интеграцчилах үндсэн дээр олон соёлтой болгож хөгжүүлэх, нийгмийн ажлын дадлагын туршлагыг баяжуулах, өөрийн үйл ажиллагааны үр дүн, үр дагаврын төлөө нийгмийн хариуцлага хүлээх чадвартай идэвхтэй зүтгэлтэн, соёлт хүн болгож төлөвшүүлэх нөхцөл нь болсон эрэн сурвалжлах, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа зэргийг тэргүүлэх чиглэл болгон товлож онцлох боломжийг олгож байна.

Орчуулсан: МУБИС-ийн БС-ийн Математик, Байгалийн ухааны тэнхимийн багш, магистр Б.Хадбаатар

БС-ийн Математик, Байгалийн ухааны тэнхимийн эрхлэгч, доктор Д.Энхцэцэг